



USAID
АМЕРИКИЙН АРД ТҮМНЭЭС



Эдийн засгийн бодлогын шинэтгэл,
өрсөлдөх чадварын төсөл

ЭЗБШӨЧ ТӨСЛИЙН САР ТУТМЫН ЦУВРАЛ

2007 оны 4 дүгээр сар

Арилжааны банкууд хувийн Зээлийн мэдээллийн сан байгуулах тухай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав

Зээлийн холбогдолтой мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн компани байгуулах тухай Харилцан ойлголцлын санамж бичигт (ХОСБ) гарын үсэг зурах ёслолын арга хэмжээ энэ оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Монголын Банкуудын холбооны (МБХ) байранд болж арилжааны 13 банк, банк бус санхүүгийн 3 байгууллага уг санамж бичигт гарын үсэг зурав. Гарын үсэг зурсан эдгээр байгууллагууд нь Монголын арилжааны ба хэрэглээний нийт зээлийн үйл ажиллагааны 95 хувийг эзэлдэг.



Дараах ажлыг гүйцэтгэх ажлын хэсэг байгуулах тухай уг Санамж бичигт заасан байна. Үүнд:

- Бизнес төлөвлөгөө боловсруулах
- Хувийн зээлийн мэдээллийн шинэ сан байгуулахын оронд одоо Монгол Банкны дэргэд үйл ажиллагаагаа явуулж буй ЗМС-г хувьчлах талаар стратегийн шийдвэр бүхий зөвлөмж гаргах
- Хувийн ЗМС-ийн үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих эрх зүйн шинэчлэгдсэн хүрээг бий болгох ажлыг удирдан чиглүүлэх
- ЗМС-ийн мэдээллийг хэн ашиглах, хэн хувь нийлүүлэгч байх талаар зөвлөмж гаргах
- Компанийн бүтцийн талаар санал гаргах
- Техник, санхүүгийн туслалцааны талаар стратегийн боломжит түншүүдтэй холбоо тогтоож, ярилцан тохиролцох.

Энэхүү санамж бичиг нь 2 дугаар сарын 28-ны өдөр ЭЗБШӨЧ төслийн дэмжлэгтэйгээр Монголын Банкуудын Холбоон дээр байгуулсан гэрээний дагуу байгуулагдсан анхны ажлын хэсгийн ажлын үр дүн юм. Анхны ажлын хэсэгт Монгол Банк, ХАС Банк, Худалдаа Хөгжлийн Банк, Капитрон Банк ба МБХ-ны төлөөлөгч бүхий 5 гишүүн багтаж байв. 4 дүгээр сарын 10-нд гарын үсэг зурсан ХОСБ нь хувь нийлүүлэгчдийн саналыг тусгаж, хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оруулсны эцэст бэлэн болсон болно.

ХОСБ-т гарын үсэг зурсны дараа ажлын хэсгийн гишүүд, ЭЗБШӨЧ төслийн төлөөлөгчдийн хамт Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) Дэлхийн зээлийн сангийн багийнхантай уулзав. Тус багийнхан Монголд хувийн ЗМС байгуулах үйл ажиллагаанд оролцох боломжийг судлах зорилгоор тус улсад айлчилсан байна.

ОУСК-ын багийнхан ажлын хэсэг, том банкууд ба Монгол Банкны төлөөлөлтэй хэд хэдэн удаа уулзаж, хувь нийлүүлэгчдэд презентаци тавьсны дараа хувийн ЗМС-г хөгжүүлэх чиглэлээр ажлын хэсэг ба ЭЗБШӨЧ төслийнхэнтэй хамтран ажиллах талаар харилцан тохиролцлоо.

Энэхүү тохиролцооны хүрээнд ОУСК зардлыг хувааж санхүүжүүлэх үндсэн дээр тохирох тоног төхөөрөмж нийлүүлэх компани болон үйл ажиллагаа явуулах түнш байгууллагыг сонгоход дэмжлэг үзүүлэх замаар ЗМС-ийн үйл ажиллагаанд техникийн туслалцаа үзүүлэхээр болов.

ЭЗБШӨЧ төслөөс хувийн ЗМС-ийн үйл ажиллагааг явуулахад зохих эрх зүйн орчинг бий болгох талаар техникийн туслалцаа үзүүлж ажлын хэсэгт зөвлөгөө өгөх үйлчилгээгээ үргэлжлүүлэхээр байх бөгөөд ажлын хэсэгт зөвлөгөө өгөх үүрэг бүхий олон улсын зөвлөхийг 4 дүгээр сарын 30-аас ажилуулснаар бидний эрх зүйн чиглэлийн ажил эхэлсэн болно.

Бизнесийн холбогдолтой шинэчилсэн хуулиудыг багтаасан шинэ CD-г Хууль зүйн үндэсний төвөөс гаргав

"Бизнесийн холбогдолтой Монгол улсын хуулиудыг" багтаасан хоёр дахь CD гарсан тухай 4 дүгээр сарын 3-нд Хууль эрх зүйн үндэсний төвд (ХЭЗҮТ) зохион байгуулсан хэвлэлийн бага хурал дээр ХЭЗҮТ-ийн дарга д-р.Амарсанаа мэдэгдэж, Олон нийттэй харилцах албаны дарга Баянбилэг CD-ний агуулгын талаар уригдсан зочид, хэвлэл мэдээллийнхэнд танилцуулав.

Энэхүү CD нь бизнесийн холбогдолтой гол хуулиудын талаар хөрөнгө оруулагчид болон олон нийтийг мэдээллээр хангахад чиглэсэн ХЭЗҮТ, ЭЗБШӨЧ төслийн хамтарсан хүчин чармайлтын үр дүн юм.



Бизнесийн холбогдолтой шинэчилсэн хуулиудыг монгол, англи хэл дээр мөн Монгол улсын нэгдсэн олон улсын хөрөнгө оруулалт, татварын гэрээнүүдийг багтаасан анхны CD 2004 оны 9 дүгээр сард гарсан билээ.

Энэхүү хоёр дахь CD –нд бизнесийн холбогдолтой 47 хуулийг нэмж оруулж нийт 67 хуулийг багтаасан бөгөөд одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй бүх олон улсын хөрөнгө оруулалт, татварын гэрээнүүдийг оруулсан болно.

Уг CD-нд өдөр тутам бизнесийн үйл ажиллагаа явуулахад шаардагддаг хувь хүний орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар ба онцгой албан татварын тухай хуулиудыг багтааснаас гадна Монголд бизнесийн орчинд ороход хөрөнгө оруулагчдад хэрэг болох Үндсэн хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай зэрэг хуулиудын талаарх мэдээлэл оржээ.



Эдгээр хуулиудыг УИХ-ын 2006 оны намрын чуулган болон түүнээс өмнөх чуулгануудаар өөрчилсөн байдлаар оруулахыг хичээсэн болно. Анхны CD-нд оруулсан зарим хуулиуд эсхүл хүчингүй болсон эсхүл нэмэлт өөрчлөлт оросноос гадна зарим шинэ хуулиуд ч мөн өөрчлөн шинэчлэгдсэн байгаа билээ. Монголын эрх зүйн орчин байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж буй энэхүү нөхцөлийг харгалзан цаашид гарах CD-нд шинээр гарсан хуулиуд болон нэмэлт өөрчлөлт орсон одоогийн мөрдөж буй хуулиудыг оруулахаар төлөвлөж байна.

Уг CD- нь 20,000 төгрөгөөр үнэлэгдсэн бөгөөд ХЭЗҮТ-өөс худалдаж авах боломжтой. (Хаяг: Сүхбаатарын гудамж- 7, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар- 46. Утас: 31 91 44). Мөн эдгээр хууль, гэрээнүүдийг бүрэн эхээр нь ХЭЗҮТ-ийн вэбсайтаас авч болно (www.legalcenter.mn). CD-ний хэрэгцээ их байгааг зөвхөн эхний сард 150 гаруй ширхэг CD шуурхай борлогдсон баримт гэрчилж байна гэж ХЭЗҮТ-өөс мэдэгдэв.

Ажлын бус өдрийн уулзалтын үеэр хувийн болон улсын хэвшлийнхэн аялал жуулчлалын үндэсний стратегийг зөвшөөрлөө

Монголын нууц товчоо жуулчлалын баазад 4-р сарын 6-8-ны өдрүүдэд болсон Монголын аялал жуулчлалын салбарын төлөөлөгчдийн гурван өдрийн уулзалтаар аялал жуулчлалын үндэсний байгууллага (ҮАЖБ)-ыг байгуулах ажлыг нэг алхмаар урагшууллаа. ЭЗБШӨЧ төслийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан энэхүү уулзалтад Зам, тээвэр, аялал жуулчлалын яам (ЗТАЖЯ)-ны гол шийдвэр гаргагчид, орон нутгийн засаг захиргаа, хувийн хэвшлийн холбоод, донор байгууллагууд нэг дор цуглаж, ҮАЖБ-ын эрх зүйн боломжит бүтэц, түүний гишүүнчлэл, үүрэг ролийн талаар хэлэлцэж, санхүүжилтийн төрөл бүрийн механизмуудын талаар авч үзэв.

Саяхан ЗТАЖЯ-наас санал болгож, салбарын зүгээс өргөн дэмжлэг авсан аялал жуулчлалын салбарын стратегийн гол

үндэс нь ҮАЖБ гэж үзэж байгаа юм. Уг уулзалт нь сүүлийн хэдэн сарын турш төслөөс зохион байгуулсан ажлын хэсгийн хэд хэдэн уулзалтуудын үр дүн байлаа.

Уулзалтад оролцогсод ҮАЖБ-ыг байгуулахтай холбоотой асуудлуудыг судлах ажлын гурван хэсгийг байгуулсан юм. Нэгдэх ажлын хэсэг нь Монгол улсын одоогийн хуулиудын хүрээнд энэ төрлийн байгууллагыг байгуулахад эрх зүйн хувьд ямар хэлбэрт байх асуудлыг судлахад төвлөрсөн бол хоёрдахь ажлын хэсэг нь ҮАЖБ-ын үүрэг роль, үйл ажиллагааг тодорхойлох, гуравдахь ажлын хэсэг нь санхүүжилтийн механизмыг тодорхойлох чиглэлээр ажилласан юм. Бүлэг бүр дотроо зөвлөлдсөний эцэст бусад оролцогчдод өөрсдийн дүгнэлтээ танилцуулсан.

Олон улсын туршлагад суурилсан бүлгийн хэлэлцүүлгийг дотоодын аялал жуулчлалын шийдвэр гаргах байгууллага, салбарын бүх байгууллагуудын төлөөллөөр дамжуулан буюу ерөнхийдөө улсын болон хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр дамжуулан сурталчлах нь хамгийн үр дүнтэй байдаг гэсэн таамаглалд суурилж явуулсан. Хэдийгээр тухайн улс орны онцлогоос хамаарч ҮАЖБ-уудын хэлбэр, бүтэц ялгаатай байж болох боловч эдгээр байгууллагууд нь ерөнхийдөө зочлох орны маркетинг, мэргэжлийн сургалт, сайн дурын үндсэн дээр гэрчилгээжүүлэх, тухайн улсын аялал жуулчлалын мэдээлэл ямар байх нөхцлийг хянах хариуцлагыг хүлээдэг. Түүнчлэн эдгээр байгууллагууд нь хөрөнгийн зарцуулалтыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмблэн хэдий хэмжээнд зарцуулах талаар шийдвэр гаргах чухал хариуцлагыг хүлээдэг. ҮАЖБ-ууд нь эрүүл мэнд, аюулгүйн ажиллагаа, байгаль орчин, хөдөлмөр хамгааллын асуудлаар засгийн газартай хамтарч ажиллах бөгөөд аялал жуулчлалын хөгжилд саад болж буй асуудлуудыг шийдвэрлүүлэх чиглэлээр төв засгийн газар, орон нутгийн засаг захиргааг лобидож ажилладаг байна.



Уулзалтын төгсгөлд ҮАЖБ-ын бүтэц, үүрэг ролийн талаар зөвшилцөлд хүрсэн бөгөөд салбарын энэхүү санаачлагыг өргөн хүрээнд дэмжиж зохион байгуулах үүргээ цаашид үргэлжлүүлэхийг ЭЗБШӨЧ төслөөс хүссэн юм. ЭЗБШӨЧ төслийн зүгээс санал болгож байгаа ҮАЖБ-ыг байгуулах ажлыг түргэвчлүүлэхэд техникийн болон хууль зүйн туслалцаа үзүүлэхийг зөвшөөрлөө.

Монголын татварын байцаагчдад зориулсан татварын аргачлал, маягтуудын талаархи үндэсний сургалт

Монгол улсын өнцөг булан бүрээс цугларсан 78 татварын байцаагчид 4-р сарын 18-19-ний өдрүүдэд Улаанбаатар

хотноо болсон гурван өдрийн сургалтанд оролцож, шинээр батлагдсан татварын хуулиудыг хэрэгжүүлэх шинэчилсэн аргачлалуудыг боловсруулах, татварын шинэчилсэн маягтуудын талаархи сургалтанд хамрагдлаа. Уг сургалтыг Үндэсний Татварын ерөнхий газар Төслийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан бөгөөд холбогдох презентаци, материал болон кейс жишээг бэлтгэсэн юм.

Сургалтын эхний өдрийг Олон улсын санхүүгийн тайлагналын (ОУСТ) стандартыг зааж сургахад зориулав. Татварын шинэ хуулиар олон улсын нягтлан бодох бүртгэлийн дүрмийг зохих ёсоор ойлгох шаардлага гарч байгаа бөгөөд учир нь энэ дүрмээр татвар ногдох орлогыг тодорхойлж, санхүүгийн тайлан мэдээллийг шалгах юм. ЭЗБШӨЧ төслийн Нягтлан бодох бүртгэлийн зөвлөх Д. Мөнхсайхан эхний өдрийн сургалтыг удирдан явуулж, олон улсын стандартын хамгийн сүүлийн үеийн мэдээлэл болон стандарт тус бүрийн хувьд хүлээн зөвшөөрсөн орлого болон зардлын зохих шаардлагыг гүнзгийрүүлэн тайлбарласан нэмэлт материалыг танилцуулсан юм.

Хоёрдахь өдрийн сургалт нь хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ)-ын хууль болон аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)-ын хуулийг хамарлаа. Эдгээр хуулиуд нь өмнө үйлчилж байсан хуулиудаас ихээхэн ялгаатай учраас шинэ заалтууд болон хууль хэрэгжүүлэх аргачлалуудыг дэлгэрэнгүйгээр тайлбарлах шаардлагатай байв.



ҮТЕГ-ын татварын байцаагч н. Баяраа аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийг бүхэлд нь, шинэ заалтуудтай холбоотой анхаарах асуудлууд, тухайлбал орлогын ангилал, үнэ шилжилт, татварын алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох, хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлт, хасагдах зардлуудын талаар дэлгэрэнгүйгээр тайлбарлав. Сургалтын асуулт, хариултын хэсэгт хуулийн хэрэгжилтийн явцад хуулийг хэрэгжүүлэх аргачлалуудыг сайжруулах хэрэгцээ байгааг оролцогчид зөвшөөрсөн юм.

ААНОАТ-ын хуулийн талаархи сургалтын дараа ЭЗБШӨЧ төслийн Татвар, нягтлан бодох бүртгэлийн зөвлөх Ларри Женсен шинэ хуульд тусгасан олон улсын туршлагаудын талаар оролцогчдод тайлбарлав.

Энэ өдрийн үдээс хойш ҮТЕГ-ын татварын байцаагч х. Туул ХХОАТ-ын хуулийн талаар сургалт явуулав. х. Туул нь татварын байгууллагад олон жил ажилласан туршлагатай мэргэжилтэн бөгөөд тэрбээр шинэ хуульд орсон гол өөрчлөлтүүд болон өөрчлөлт тус бүрийг жишээгээр дэлгэрэнгүй тайлбарлалаа. Шинэ хууль нь өнгөрсөн хугацаанд гарч байсан олон хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэсэн юм. Үүнд шууд бус орлого, холбоотой талуудын ажил гүйлгээ, хувиараа хөдөлмөр эрхлэлтийн

орлого, урлагийн тоглолтын орлого зэрэг орж байна. х. Туулаас татварын байцаагчдад хүргэсэн гол зүйл бол Парламентаар баталсан "сайн" хуулийг хэрэгжүүлэхэд илүү их хүчин чармайлт гаргахын чухлыг ойлгуулсан явдал байв.

Дээрх хоёр багш хоёулаа шинэ хуулийн дагуу гаргах орлогын албан татварын тайлангийн маягтуудыг танилцуулж, ҮТЕГ-аас боловсруулсан цахим хэлбэрт маягтуудыг хэрхэн бөглөхийг жишээгээр харуулж тайлбарлав. Татварын эрх бүхий байгууллагаас татварын тайланг нэгдсэн, илүү хялбар, боловсронгуй болгох ажил хийгдэж байгаатай холбоотойгоор уг сургалт нь эдгээр маягтуудын талаар татварын байцаагчид өөрсдийн саналаа өгөх боломжийг олголоо.

Гуравдахь өдөр Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль, онцгой албан татварын хууль, татварын тооцоо, нягтлан бодох бүртгэлийн асуудлуудыг хамарсан сургалт явуулав. ҮТЕГ-ын мэргэжилтэн н. Буянбадрах НӨАТ-ын хууль, холбогдох аргачлалууд болон маягтуудын талаар тайлбарлав. Түүний презентаци татвар бууруулсан хувь хэмжээ, татвараас чөлөөлөх нөхцлийг цөөрүүлсэн болон шинэ хуулийн заалтуудыг тодруулахад чиглэгдсэн юм. Сургалтанд хамрагдсан татварын байцаагчдаас асуусан асуултууд нь татварын албаны үйл ажиллагаа, олон жилийн туршид татварын байгууллагад тулгарч буй хүндрэлтэй асуудлуудтай холбогдож байлаа. н. Буянбадрах НӨАТ-ын шинэ маягтыг бөглөхтэй холбоотойгоор гарч буй хүндрэлүүд болон бусад асуудлуудын талаар тайлбарлав. Нэмэгдсэн өртгийг татвар төлөгчид сар бүр орлогын албан татварын тайлангаа гаргаж байгаа учраас уг маягтыг хэдийнээ бөглөж эхлээд байгаа юм.

н. Октябрь-Эрдэнэ онцгой албан татварын талаар сургалт явуулж, мөрийтэй тоглоомын үйл ажиллагаанд татвар ногдуулах, импортоор оруулж ирсэн автомашинд ногдуулж буй ялгаатай татвар болон архины төрлийн бүтээгдэхүүнд ижил сууриар татвар ногдуулах шинэ заалтуудын талаар тайлбарлав.

Татварын дөрвөн шинэ хуулийн талаархи сургалт өндөрлөсний дараа ҮТЕГ-ын мэргэжилтэн х. Уранчимэг, төслийн зөвлөх Мөнхсайхан нараас сургалтын үеэр суралцагчдаас гарсан шинэ хуулиудтай холбоотой нягтлан бодох бүртгэл, тооцооны асуудлуудад хариулав. х. Уранчимэг татварын тооцоог журналд хэрхэн бичилт хийх талаар тодорхой жишээгээр тайлбарлав, н. Мөнхсайхан үл хөдлөх хөрөнгө, түүнийг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад хэрхэн тооцдог тухай дэлгэрэнгүй тайлбарлав. Татварын байцаагчдад үл хөдлөх хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд хэрхэн тусгах талаар хамгийн сүүлийн үеийн аргачлал шаардлагатай байгаа бөгөөд учир нь ААНОАТ-ын шинэ хуулийн дагуу түүний элэгдлийг бүрэн хэмжээнд хасах ёстой болж байгаа юм.

Үнэлгээ, цаашид хэрхэх талаар

Монгол улсын өнцөг булан бүрээс цугларсан татварын байцаагчдад зориулсан дээрх сургалт нь татварын хуулиудыг хэрэгжүүлэхэд татварын албаны үйл ажиллагааг сайжруулах, ҮТЕГ-ыг дэмжих чиглэлд Төслөөс үзүүлж буй дэмжлэг туслалцааны нэг хэсэг юм. Сургалтанд оролцогчид шинэ хуулиуд, аргачлалуудын төсөл, татварын маягтуудын хувьд ихээхэн сайжирсан боловч цаашид аргачлалуудыг сайжруулах, маягтуудыг боловсронгуй болгоход хийгдэх ажил нэлээд байгааг хүлээн зөвшөөрөв.

Сургалтын үеэр шинээр боловсруулсан аргачлалуудын төсөл, татварын маягтуудын талаар олон тооны асуултууд гарч байсан ба зарим ойлголт тодорхойлолтууд, заалтуудын агуулгын талаар шүүмжилж, илүү тодорхой, дэлгэрэнгүйгээр тайлбарласан аргачлал боловсруулах шаардлага байгааг онцолж байв. Сургалтанд оролцогчид зохих аргачлалуудыг боловсруулах, тэдгээрийг ойлгомжтой, тодорхой болгох, түүнчлэн санал болгож буй шинэ маягтуудыг боловсронгуй

болгоход ихээхэн ажил хийгдэх шаардлагатай байгааг зөвшөөрлөө. Төсөл ҮТЕГ-аас холбогдох аргачлал, маягтуудыг шинэчлэх, боловсронгуй болгоход шаардагдах дэмжлэг туслалцааг үргэлжлүүлэн үзүүлэх юм.

Сургалтанд оролцогчид өөрсдийн ажиллаж буй татварын албандаа буцаж очсоны дараа Улаанбаатар хотноо болсон сургалтад оролцож чадаагүй татварын байцаагчид, татвар цуглуулагчдад сургалт явуулна. Түүнчлэн эдгээр оролцогчид ҮТЕГ, Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим (МҮХАҮТ) болон ЭЗБШӨЧ төслөөс удахгүй хамтран зохион байгуулах татвар төлөгчдийн боловсролыг дээшлүүлэх сургалтад оролцож, сурсан мэдсэн зүйлээ зааж сургах болно.

Энэхүү цуврал нь ЭЗБШӨЧ төслийн үйл ажиллагааны сар тутмын цахим хэвлэл юм. Та манай цувралын талаархи өөрийн санал бодлоо, мөн манай цувралыг захиалах болон захиалгаа цуцлах хүсэлтээ ЭЗБШӨЧ төслийн цувралын эрхлэгчид дараахь хаягаар ирүүлнэ үү. Имэйл: fbertoli@eprc-chemonics.biz, факс: (976-11) 32 78 25.